



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрэнцэв хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/018/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



“ЭРЭЭНЦАВ ХӨГЖИЛ” ОНӨҮГ-ЫН
ДАРГА Ц.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.03.13 № 361

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрэнцав хөгжил” ОНӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудлууд

Тус байгууллага нь зорилтот түвшний гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталдаггүй, тайлант хугацаанд ашигтай ажиллах зорилт тавьдаггүй, төсөвт байгууллагатай адилаар төсөв баталдаг ба өөрийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр 108,850.0 мянган төгрөгийн орлого олсон байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн жилийн төлөвлөгөөг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

2126050097

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	743,108.56	20,732.14
1.1.2	Дансны авлага	-	49,160,700.00
1.1.6	Бараа материал	22,796,500.00	6,589,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	23,539,608.56	55,770,432.14
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,853,101,596.37	3,773,596,634.51
1.2.2	Биет бус хөрөнгө	22,796,500.00	29,980,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,883,081,596.37	3,803,576,634.51
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,906,621,204.93	3,859,347,066.65
2.1.1.1	Дансны өглөг		41,625,425.40
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		41,625,425.40
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Өмч	3,847,192,222.10	3,704,705,596.77
2.3.1	төрийн	-	
2.3.2	хувийн	-	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	206,820,346.23	201,915,608.16
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(147,391,363.40)	(88,899,563.68)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,906,621,204.93	3,817,721,641.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,906,621,204.93	3,859,347,066.65

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	22,626,795.50	3,550,000.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	22,626,795.50	3,550,000.00
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	16,207,500.00	165,300,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	171,605,103.19	239,749,563.94
11	Санхүүгийн зардал		-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(14,620,555.71)	(17,999,999.84)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-

17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(147,391,363.40)	(88,899,563.78)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,844,848,312.90	201,915,608.16	(145,716,052.73)	3,901,047,868.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(145,716,052.73)		145,716,052.73	-
4	Залруулсан үлдэгдэл	3,699,132,260.17	201,915,608.16		3,901,047,868.33
5	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		(147,389,363.40)	(147,389,363.40)
6	Бусад дэлгэрэнгүй орлого	-		-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	152,964,700.00		-	152,964,700.00
8	Зарласан ногдол ашиг	-		-	-
9	Тайлант үеийн үр дүн	-			
10	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,852,096,960.17	201,915,608.16	(147,389,363.40)	3,906,623,204.93
11	2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	3,852,096,960.17	201,915,608.16	(147,389,363.40)	3,906,623,204.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		-	-
14	Залруулсан үлдэгдэл				
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-		(94,457,238.43)	(94,457,238.43)
16	Бусад дэлгэрэнгүй орлого	-		-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	(147,391,363.40)		152,947,038.15	5,555,674.75
18	Зарласан ногдол ашиг	-		-	-
19	Тайлант үеийн үр дүн	-			
20	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,704,705,596.77	201,915,608.16	(88,899,563.68)	3,817,721,641.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн		
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	22,626,795.50	59,689,300.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	25,793,839.55	25,991,353.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	10,430,981.77	17,369,939.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,765,280.00	4,063,980.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	7,807,300.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	1,020,722.90	2,428,139.70
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,281,671.00	5,375,301.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,009,937.20	3,401,216.72
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	143,250.00	286,200.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	804,500.00	19,681,600.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(829,547.37)	(724,376.42)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,574,655.93	745,108.56
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	745,108.56	20,732.14

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	Зөрүү			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	22,626,795.50		108,850,000.00	108,850,000.00	-
Бусад орлого	169,172,200.00	-	60,000,000.00	60,000,000.00	-
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	191,798,995.50	-	168,850,000.00	168,850,000.00	-
Цалин хөлс	-	-	18,702,540.00	18,702,540.00	-
Байгууллага НДШ зардал	-	-	4,063,980.00	4,063,980.00	-
Байрны түрээс	-	-	2,428,139.70	2,428,139.70	-
Хангамжийн бараа материалын зардал	-	-	35,365,301.00	35,365,301.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	37,641,169.81	-	33,209,841.12	33,209,841.12	-
Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз	-	-	17,999,999.84	17,999,999.84	-
Элэгдлийн зардал	148,584,489.09	-	145,979,762.02	145,979,762.02	-
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	186,225,658.90	-	257,749,563.68	257,749,563.68	-
ТАТВАР	-	-		-	-
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ	5,573,336.60	0.00	-88,899,563.68	-88,899,563.68	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 62,005.1 мянган төгрөгийн дараах 1 алдааг¹ аудитын явцад залруулаагүй тул зөвлөмж өгөв. Үүнд:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй наадмын талбайг өргөтгөн засварлах төсөл, арга хэмжээнд 62,005.2 мянган төгрөг олгосныг сумын ЗДТГ-ын өмчлөлд бүртгэснийг УСНББОУС 1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, эздийн өмчийн тайланд нэмж д дараагийн тайлант үед дуусаагүй барилгаар бүртгэж залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 422,758.9 мянган төгрөгийн зөрчил²-д 422,758.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс шинж чанарын хувьд материаллаг, нийцлийн аудитаар илэрсэн асуудлаас бусад санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй алдаа болон зөрчил илрээгүй бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан зөрчил гараагүй тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

5.1 Зөвлөмж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Гэрээ байгуулахтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын удирдлага нь дээд шатны байгууллагатай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, тайлангаа дүгнүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. гэрээнд дараах нөхцөлийг тусгана” , 19.1.11-д “Гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, хугацаа” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг баримтлан, дээд шатны захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах

2. Санхүүгийн тайлангийн маягттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт "Санхүүгийн тайлангийн маягт" дагуу бэлтгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 дахь заалтыг баримтлан, санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэх.

3. Эзэмшигчийн өмчтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс 407,758.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 болон 13.1 дэх заалтыг баримтлан, улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх дүнгээр санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг залруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

4. Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Шилэн дансны 158 мэдээнээс 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнээс 15,000.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг баримтлан, мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хөрөнгийг бүртгэлд тусгаагүй.	1	62,005.1	1	62,005.1					1	62,005.1	1	62,005.1
Дүн	1	62,005.1	1	62,005.1					1	62,005.1	1	62,005.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын гэрчилгээ дээрх өмчийн дүн санхүүгийн тайлан дээрх өмчийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	407,758.9					1	407,758.9				

Дүн	1	407,758.9	-	-			1	407,758.9	-	-	-	-
------------	----------	------------------	---	---	--	--	----------	------------------	---	---	---	---

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар												
Тайлант хугацаанд оруулбал зохих 158 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 10,200.0 мянган төгрөгийн 2 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй	1	15,000.0					1	15,000.0				
Санхүүгийн тайланг аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн маягтаар бэлтгээгүй, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтаар бэлтгэсэн	1	-					1	-				
Дүн	2	15,000.0	-	-			2	15,000.0	-	-	-	-